

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны ...дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар ..

Улаанбаатар
хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1, 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Журам батлах тухай” Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/01 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хүнд үйлдвэрийн салбарын мэргэжилтэнд мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох журам”-ын 1.5 дахь заалтын “өндөр ёс зүйтэй,...” гэсний дараа “мэргэшсэн инженерийн сургалтанд хамрагдсан” гэж, 1.6 дахь заалтын “Зөвлөх инженер гэж...”-гэсний дараа “мэргэшсэн инженерийн зэрэгтэй” гэж тус тус нэмсүгэй.
2. Журмын 3 дугаар хавсралтаар баталсан “Салбарын мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг олгох хүрээ” хэсэгт “Химичийн мэргэших хүрээнд” :
 - 2113-15 Резиний химич
 - 2113-18 Будгийн химич
 - 2113-23 Нийлэг материалын химич
 - 2113-27 Төмөрлөгийн химич
 - 2113- 28 Усны химич
 - 2113-30 Хуванцарын химич
 - 2113-35 Шилны химич
 - 2113 Химич /2113-40 ээс 2113-47/
 - 2113-50 Химич, газрын тосны технологичгэсэн 6 дугаар заалтыг нэмсүгэй.
3. Журмын 1.6 дахь заалтын “...15-аас доошгүй жил салбарт” гэснийг “...20-иос доошгүй жил мэргэжлээрээ” гэж, 1.7 дахь заалтын “...шийдвэрүүдийг 2 хувь үйлдэж салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон сургалт явуулж буй байгууллагын мэдээллийн санд архивын нэгж болгон хадгална” гэснийг “...шийдвэр, мэргэжлийн зэргийн үнэмлэхний хуулбар, тамганы дардсыг сургалт явуулж буй байгууллагын мэдээллийн санд архивын материал болгон хадгална” гэж, 2.3 дахь заалтын “...төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргын” гэснийг “сайдын” гэж, 3.5 дахь заалтын “Зөвлөлөөс томилсон мэргэжлийн ерөнхий

мэдлэгийн шалгалтын комисс нь шалгалтыг тест хэлбэрээр авна. Зэрэг горилогч нь шалгалтанд 80 болон түүнээс дээш онооны амжилт үзүүлсэн тохиолдолд сургалтанд хамрагдах эрхтэй болно” гэснийг “Зөвлөлөөс томилсон шалгалт авах комисс нь мэргэжлийн ерөнхий мэдлэгийн болон мэргэжлийн ур чадварын шалгалт зохион байгуулна” гэж, 4.6 дахь заалтын “...1 сараас” гэснийг “21 хоногоос” гэж, 7.7 дахь заалтын “Мэргэшсэн инженерийн зэрэг 3 жил...” гэснийг “Мэргэшсэн инженерийн зэрэг 5 жил” гэж тус тус өөрчилсүгэй.

4. Журмын 5 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

Ерөнхий мэдлэгийн шалгалт, шалгаруулалтын удирдлага зохион байгуулалт

5.1.1. Салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэлт, мэргэжлийн зэрэг олгох, сунгах, ахиулах сургалт, шалгалтыг Зөвлөлөөс баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.

5.1.2. Салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэлт, мэргэжлийн зэрэг олгох, сунгах, цуцлах сургалт, шалгалтыг төлөвлөж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд салбарын чиглэлийн зөвлөх, тэргүүлэх, мэргэшсэн зэрэгтэй мэргэжилтнүүд болон мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагыг татан оролцуулна.

5.2. Шалгалт, шалгаруулалт явуулах комиссын чиг үүрэг

5.2.1. Зөвлөл нь Мэргэшсэн болон Зөвлөх инженерийн зэрэг олгох шалгалт авах комиссыг /цаашид “Комисс” гэх/ тухай бүрд нь томилж ажиллуулна.

5.2.2. Комисс нь ашиг сонирхолын зөрчилгүй хөндлөнгийн гишүүдээс бүрдсэн байна.

5.2.3. Комисс нь сургалтын байгууллагаас ирүүлсэн нэрсийн жагсаалтанд орсон зэрэг горилогчдоос мэргэжлийн ерөнхий мэдлэгийн шалгалтыг зөвхөн нэг удаа тест хэлбэрээр авна. Мэргэжлийн болон ур чадварын шалгалтыг мэргэшсэн зэрэг горилогчид нэг, зөвлөх зэрэг горилогчид хоёр хүртэл үе шаттайгаар явуулна.

5.2.4. Комисс мэргэжлийн ерөнхий мэдлэгийн шалгалтанд 70 болон түүнээс дээш оноо авсан зэрэг горилогчдын шалгалтын хуудсыг сургалтын байгууллагад өгч сургалтанд хамруулах үйл ажиллагааг эхлүүлнэ.

5.2.5. Комисс мэргэжлийн болон ур чадварын шалгалтанд 80 буюу түүнээс дээш оноо авсан мэргэшсэн инженер, 80 буюу түүнээс дээш оноо авсан зөвлөх инженерийн материалыг зөвлөлд хүргүүлж зэрэг олгох асуудлыг шийдвэрлүүлнэ.

5.3. Мэргэжлийн зэрэг олгох шалгалтын ажиллагаа

5.3.1. Шалгалтын комисс нь мэргэжилтний мэргэшлийн мэдлэгийн түвшин, ур чадварыг шалгалтаар, бүтээл, туршлагыг ажил байдлын тодорхойлолт, бүтээлийн тайланг зохих журмын дагуу магадлан шалгах замаар тодорхойлно.

5.3.2. Мэргэшлийн ерөнхий мэдлэгийн түвшин тогтоох шалгалтыг тестээр 90 минутын хугацаанд авна. Мэргэжлийн ерөнхий мэдлэгийн шалгалтанд 70% түүнээс дээш оноо авсан тохиолдолд сургалтанд хамрагдана. Тэнцээгүй тохиолдолд зэрэг горилогчид нь дараагийн зарлагдах сургалтанд хамрагдан шалгалт өгөх эрхтэй.

5.3.3. Мэргэшлийн зэрэг олгох шалгаруулалт нь хоёр хүртэл үе шаттайгаар явагдана. Үүнд:

а. Нэгдүгээр шат. Мэргэжлийн шалгалт /мэргэжлийн чиглэлийн мэдлэг, ур чадвар болон салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт, журам, зааврын талаарх мэдлэгийг шалгах/ Шалгалтыг сургалтын явцад зохион байгуулж болно.

б. Хоёрдугаар шат. ТЭЗҮ, төсөл, тайлан, сэдвийн хамгаалалт /илтгэлийн хураангуй /реферат/ бичих, техник технологийн шийдэл, ТЭЗҮ боловсруулах/

5.3.4. Мэргэшсэн зэрэг горилогч нь мэргэжлийн болон мэргэжлийн ур чадварын шалгалтанд авбал зохих нийт онооны 80 буюу түүнээс дээш хувь, зөвлөх зэрэгт ахиулан горилогч нь 80 буюу түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн бол тэнцсэнд тооцно.

5.3.5. Мэргэжлийн шалгалтыг бичгээр, тест, зураг тооцоо, загвар, бодит бүтээл зэргээр авна.

5.3.6. Мэргэшлийн хүрээний чиглэлээр докторын зэрэг хамгаалсан тохиолдолд зөвлөх зэрэг горилогчийн бичгээр уламжилсан хүсэлтийг үндэслэн зөвхөн мэргэжлийн шалгалтаас чөлөөлж болно. Харин реферат хамгаалалт болон төсөл, ТЭЗҮ хамгаалалтанд оруулна.

5.3.7. Зэргийн хугацаагаа сунгуулж буй мэргэжилтэн нь өөрийн мэргэжлийн чиглэлээр норм, дүрэм, стандарт, техникийн баримт бичиг боловсруулсан болон санал, шүүмж, дүгнэлтийг мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн материалаа мэдээллийн сан болон архивт хадгалуулсан байна. Энэхүү санал, дүгнэлтээ тайлан хамгаалалтанд бүрдүүлэх материалд хавсаргасан байна.

5.3.8. Эхний шатны шалгаруулалтад тэнцээгүй зэрэг горилогч нь дараагийн шатны шалгаруулалтад орох эрхгүй болно.

5.3.9. Зөвлөх зэрэг горилогчийн ТЭЗҮ болон илтгэл /реферат/-ийг салбарын тухайн мэргэжлийн чиглэлийн зөвлөх зэрэгтэй болон эрдмийн зэрэг цолтой мэргэжилтнээр хянуулсан байна.

5.3.10. Шалгалтын тест, бодлого, өгөгдлийг тестийн сангаас сонгох бөгөөд энэ нь шалгалт авах өдөр, цаг хүртэл байгууллагын нууцад хамаарна.

5.3.11. Зэрэг горилогчийн авсан нийт онооны нийлбэрийг шалгалтын комиссын нарийн бичгийн дарга нэгтгэн дүгнэж, дундаж оноог гаргах ба комиссын дарга энэ дүнг комиссын гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн гишүүн бүрээр гарын үсэг зуруулж баталгаажуулна.

5.3.12. Комиссын гишүүд горилогчийн илтгэл, тайлан, ТЭЗҮ-г түүний онол, техник технологийн түвшин, мэдээлэл тусгалт, үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж, нэвтрүүлсэн байдал, шинэлэг санаа, ач холбогдол, асуултад хариулсан байдал, шүүмжийн үнэлгээ зэрэг үзүүлэлтээр дүгнэж болно.

5.3.13. Комиссын нарийн бичгийн дарга нь шалгалтын нэгдсэн дүн, холбогдох материалыг цэгцэлж шалгалт дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор Зөвлөлийн гишүүн бүрд хүргэж танилцуулан, хурлаар шийдвэрлүүлнэ. Шалгалтын үнэлгээн дээр маргаантай асуудал гарвал горилогч нь гомдол, саналаа Зөвлөлд бичгээр тавьж шийдвэрлүүлнэ. Энэ шийдвэр эцсийн шийдвэр байна.

5.3.14. Шалгалтын үйл ажиллагаанд хөндлөнгийн хянагчаас гадна мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгч хяналт тавьж болно.

5.3.15. Комиссын гишүүдэд нөлөөлөхийг оролдсон, горилогчийг үндэслэлгүй дэмжиж, бусдаас хэт зөрүүтэй үнэлгээ тавьсан гишүүнийг комисс хэлэлцэж, түүний үнэлгээг комиссын нэгдсэн дүнд оруулах эсэхийг шийдвэрлэнэ.

5.3.16. Мэргэшлийн зэрэг горилогч нь шалгаруулалтад тэнцээгүй бол дахин шалгаруулалтад оролцох хүсэлтээ бичгээр гаргасны үндсэн дээр шалгаруулалтад оролцож болно. Хэрэв дахин шалгалтад 2 удаа ороод тэнцээгүй тохиолдолд дахин шалгалт өгөх эрх 1 жилээс доошгүй хугацааны дараа үүсэх бөгөөд шалгалт дахин өгөх хүсэлтийг Зөвлөлд бичгээр гаргаж шийдвэрлүүлнэ. Дахин шалгаруулалтад 3 жилийн дотор хамрагдаагүй мэргэжилтнийг дахин сургалтад хамруулна.

5.4. Зөвлөх инженерийн зэрэг горилох төгсөлтийн ажил

5.4.1. Зөвлөх инженерийн зэрэг горилоход ТЭЗҮ боловсруулна. ТЭЗҮ боловсруулахад багаар ажиллаж болно.

5.4.2. ТЭЗҮ нь хүнд үйлдвэрийн салбарт шинэ техник, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйлдвэрлэлийн удирдлага, зохион байгуулалт, өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэгдсэн, тодорхой асуудал дэвшүүлж шийдвэрлэсэн байвал зохино.

5.4.3. ТЭЗҮ нь оршил, асуудлын судлагдсан байдал, судалгаа боловсруулалт, хэрэгжүүлэлт, туршилт, тухайн ажлын үр дүн, санал дүгнэлт, ашигласан материал, хавсралтаас бүрдэнэ.

5.4.4. ТЭЗҮ-г 2 хувь үйлдэж төрийн захиргааны байгууллага, сургалт зохион байгуулсан байгууллагад хүлээлгэн өгнө.

5. Мэргэшсэн болон Зөвлөх инженерийн сургалтыг холбогдох журам, төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу зохион байгуулж ажиллахыг Үндэсний Аж Үйлдвэрийн Зөвлөл болон ШУТИС-ийн Механик Тээврийн сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны сургуульд үүрэг болгосугай.
6. Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга /Д.Даваадорж/-д үүрэг болгосугай.
7. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Хүнд үйлдвэрийн салбарын инженерүүдэд мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох тухай” Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
САЙД

Д.СУМЪЯБАЗАР



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 03 өдөр

Дугаар A/01

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1, 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хүнд үйлдвэрийн салбарын инженерүүдэд мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох журмыг нэгдүгээр хавсралтаар, салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар, мэргэшлийн зэрэг олгох хүрээг гуравдугаар хавсралтаар, салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгоход тавигдах шаардлагыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Мэргэшсэн болон Зөвлөх инженерийн сургалтыг холбогдох журам, төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу зохион байгуулж ажиллахыг Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл болон Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Механик тээврийн сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны сургуульд үүрэг болгосугай.

3. Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга /Б.Баатарсүх/-д үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Хүнд үйлдвэрийн салбарын инженерүүдэд мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох тухай” Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 89 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ц.ДАШДОРЖ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2017 оны 0/дугаар сарын 03 ны өдрийн
А/01 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТЭНД
МЭРГЭШСЭН БОЛОН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕРИЙН
ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ**

УХА0580 9129294

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь хүнд үйлдвэрийн салбарт *Ицаашид "Салбар" гэх/* ажиллаж буй инженер техникийн ажилтнуудын манлайлал, салбарын бодлого, эрх зүйн орчин, үйлдвэрлэлийн менежмент, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал, техник, технологийн процессийн мэдлэгийн түвшин, туршлага, мэргэжлийн ёс зүйг үнэлэх замаар Мэргэшсэн болон Зөвлөх инженерийн зэрэг олгох, сунгах, цуцлах харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү журмын зорилго нь салбарын хөгжлийн чиг хандлага, менежмент, техник, технологийн дэвшилд нийцүүлэн салбарт ажиллаж буй инженер техникийн ажилтнуудад шаардагдах чадавхийг нэмэгдүүлж зэрэг олгох, инженер техникийн ажилтнуудын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

1.3. Салбарын инженер техникийн ажилтан гэдэгт "Монгол улсын Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08" –д заасан дараах мэргэжил, индекс/кодтой инженер хамаарагдана. Үүнд:

1. Аж үйлдвэрийн инженер /2141-11-ээс 2141-35 хүртэл /,
2. Механик инженер /2144-46/,
3. Металлургич инженер /2146/,
4. Химийн инженер /2145/,
5. Боловсруулах үйлдвэрлэлийн менежер /1321-12,
6. "Монгол улсын Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08" –д ирээдүйд нэмэгдэж болох мэргэжлүүд

1.4. Салбарын инженер техникийн ажилтан нь Мэргэшсэн ба Зөвлөх гэсэн мэргэжлийн зэрэгтэй байна. Мэргэшсэн инженер нь тухайн үйлдвэрлэлийн түвшинд, Зөвлөх инженер нь үйлдвэрлэл болон салбарын түвшинд ажил, үйлчилгээ үзүүлнэ.

1.5. Мэргэшсэн инженер гэх мэргэжлээрээ 5-аас доошгүй жил үйлдвэрлэл дээр тогтвортой ажилласан, батламжид заасан эрхлэх ажил үйлчилгээний хүрээнд инженерийн тооцоолол хийх, үйлдвэрлэлийн технологийн процесс, туршилт, тохируулга, зүгшрүүлэлт, засвар үйлчилгээ зэрэг ажлыг удирдан гүйцэтгэх, гүйцэтгэлд хяналт тавих чадавхитай, техникийн болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн, эрх зүйн мэдлэгтэй мэргэшлийн өндөр ёс зүйтэй, тангараг өргөсөн инженер байна.

1.6. Зөвлөх инженер гэж 15-аас доошгүй жил салбарт ажилласан туршлагатай салбарын бодлого, хөгжлийн чиг хандлага, эрх зүйн орчин, үйлдвэрлэлийн менежмент, техник технологи, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, стандартчилалын талаар өргөн мэдлэгтэй, батламжид заасан эрхлэх ажил үйлчилгээний хүрээнд стандарт, техникийн зохицуулалт, үйлдвэрийн ерөнхий төлөвлөлт, техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, инженерийн зураг төсөл, дизайны ажлыг хийж гүйцэтгэх, удирдах, шинжээчийн дүгнэлт гаргах, үйлдвэр барьж байгуулах, өргөтгөх, технологийн шинэчлэл хийж хэрэгжүүлэх зэрэг

үйлдвэр барьж байгуулах, өргөтгөх, технологийн шинэчлэл хийж хэрэгжүүлэх зэрэг асуудал дээр шийдвэр гаргах түвшинд бэлтгэгдсэн, мэргэжлийн өндөр ёс зүйтэй, тангараг өргөсөн инженер байна.

1.7. Мэргэшсэн ба Зөвлөх инженерүүдийн бүртгэл, шалгалтын хуудас, зэрэг олгосон, сунгасан, цуцалсан шийдвэрүүдийг 2 хувь үйлдэж салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон сургалт явуулж буй байгууллагын мэдээллийн санд архивын нэгж болгон хадгална.

Хоёр. Мэргэшсэн болон Зөвлөх инженерийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл

- 2.1. Салбарын инженерүүдэд зэрэг олгох, сунгах, цуцлах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих ажлыг “Мэргэшсэн болон Зөвлөх инженерийн зэрэг олгох орон тооны бус Зөвлөл ” / цаашид “ Зөвлөл ” гэх / эрхэлнэ.
- 2.2. Зөвлөлийн бүрэлдэхүүн нь салбарын яамны холбогдох газар, хэлтсийн дарга, мэргэжилтэн, салбарын нэр бүхий эрдэмтэн, багш, мэргэжилтэн, салбарын чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэнэ. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сургалт зохион байгуулах эрх авсан байгууллагын саналыг үндэслэн салбар хариуцсан Засгийн газрын гишүүн томилно.
- 2.3. Зөвлөлийн гаргасан шийдвэрийг салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар баталгаажуулж сургалт зохион байгуулах байгууллага хэрэгжүүлнэ.
- 2.4. Зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах үүргийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцна.
- 2.5. Зөвлөлийн нарийн бичгийн дарга хурлын гишүүдийн ирцийг бүрдүүлэх, хурлын тэмдэглэл хөтлөх, гаргасан шийдвэрийг баталгаажуулах, холбогдох газар, харьяа байгууллагад хүргүүлэх ажлыг гүйцэтгэнэ.
- 2.6. Зөвлөлийн хурал нь 75 ба түүнээс дээш хувийн ирцтэйгээр хуралдана.
- 2.7. Зөвлөлийн ажиллах бүрэн эрхийн хугацаа 5 жил байна.
- 2.8. Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - Сургалтын хөтөлбөрийг батлах
 - Мэргэшсэн болон Зөвлөх инженерийн тангараг, батламж, энгэрийн зүүлт, баталгааны тэмдгийн загварыг батлах,
 - Сургалтын чанарыг тасралтгүй сайжруулах, шалгалтын тест боловсруулах ажилд хяналт тавих
 - Шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг тухай бүрт томилох
 - Мэргэшсэн болон Зөвлөх инженерийн зэрэг авах, сунгах, цуцлах саналыг салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх
 - Сургалтын чанарт үнэлгээ өгөх
 - Сургалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих
 - Сургалтын төлбөрийг сургалтын эрх авсан байгууллагын саналыг үндэслэн батлах.

Гурав. Сургалт зохион байгуулах үйл ажиллагаа

3.1. Салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар сургалт зохион байгуулах байгууллага нь салбарын инженер техникийн ажилтанд Мэргэшсэн ба Зөвлөх зэрэг олгох сургалтыг зохион байгуулна.

3.2. Сургалт зохион байгуулах байгууллага нь Монгол Улсын боловсролын тухай хуулийн 3 дугаар бүлэг, 6 дугаар бүлгийн 6.4 дугаар зүйлд тавьсан шаардлагыг хангасан байна.

3.3. Эрх авсан байгууллага нь /цаашид “Сургалтын байгууллага” гэх/ сургалт эхлэхээс хоёроос доошгүй сарын өмнө Мэргэшсэн ба Зөвлөх инженерийн зэрэг олгох сургалт явуулах зарыг хэвлэл, мэдээлэлийн хэрэгслээр олон нийтэд зарлана.

3.4. Зэрэг горилогч нь мэргэжлийн ерөнхий мэдлэгийн шалгалт эхлэхээс 14 хоногийн өмнө дараах баримт, бичгийг бүрдүүлж сургалтын байгууллагад ирүүлнэ. Үүнд:

- Мэргэжлийн ерөнхий мэдлэгийн шалгалтанд хамрагдахыг хүссэн өргөдөл,
- Анкет, 2 хувь зураг, хавтастай,
- Мэргэшсэн дипломын баталгаажсан хуулбар,
- Нийгмийн даатгалын дэвтрийн баталгаажсан хуулбар,
- Ажил эрхлэгчээс олгосон ажил байдлын тодорхойлолт

3.5. Зөвлөлөөс томилсон мэргэжлийн ерөнхий мэдлэгийн шалгалтын комисс нь шалгалтыг тест хэлбэрээр авна. Зэрэг горилогч нь шалгалтанд 80 болон түүнээс дээш онооны амжилт үзүүлсэн тохиолдолд сургалтанд хамрагдах эрхтэй болно.

3.6. Зэргийн хугацаа сунгуулагчаас мэргэжлийн ерөнхий мэдлэгийн шалгалт авахгүй.

3.7. Зэрэг горилогч, зэргийн хугацаа сунгуулагч нь сургалтын төлбөрийг сургалт эхлэхээс ажлын 5 хоногийн өмнө төлсөн байх үүрэгтэй.

3.8. Сургалтын байгууллага нь зэрэг горилогч, зэргийн хугацаа сунгуулагч нэг бүртэй суралцах, суралцуулах гэрээ байгуулна. Сургалтын байгууллага нь гэрээг дүгнэж, хангалттай гэж үзсэн зэрэг горилогчдын нэрсийг шалгалтын комисст хүргүүлнэ.

3.9. Сургалтын байгууллага нь Мэргэшсэн болон Зөвлөх инженерийн зэрэг олгох сургалтын хөтөлбөрийг мэргэшлийн зэрэг олгох хүрээ тус бүрээр боловсруулж, сургалтын төлбөрийн үнэлгээний хамт Зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулна.

3.10. Сургалтын байгууллага нь Зөвлөлөөс баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу Мэргэшсэн болон Зөвлөх инженерийн зэрэг олгох сургалт, шалгалтыг зохион байгуулна.

3.11. Сургалтын байгууллага нь эрхээ бусдад шилжүүлэх, ашиглуулахыг хориглоно.

Дөрөв. Сургалтын хөтөлбөр

4.1. Зөвлөл нь Мэргэшсэн болон Зөвлөх инженерийн зэрэг олгох сургалтын хөтөлбөрийг салбарын хөгжилтэй уялдуулан жил бүр шинэчлэн батална.

4.2. Сургалтын хөтөлбөрт сургалтын агуулга, сэдэв, сургалт явуулах хэлбэр, хугацааг нарийвчлан тусгана.

4.3. Сургалтын хөтөлбөрийн агуулга нь инженерүүдийн манлайлал, үйлдвэрлэлийн эдийн засаг, менежмент, эрх зүйн мэдлэг, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, мэргэжлийн ёс зүй, ажлын хариуцлага, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн байна.

4.4. Мэргэшсэн инженерийн зэрэг олгох сургалтын хөтөлбөрийн сэдэвт лаборатори, хагас үйлдвэрлэлийн туршилт явуулах, үйлдвэрлэлийн шугам, тоног төхөөрөмж угсрах, суурилуулах, туршилт, тохируулга, зүгшрүүлэлт, засвар үйлчилгээ хийх зэрэг ажлыг удирдан гүйцэтгэх, хяналт тавих чадавхийг төлөвшүүлэх, үйлдвэрт мөрдөгдөх техник, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны аргачлал, стандартыг мөрдөх, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, үүрэг хариуцлага, салбарын эрх зүйн зохицуулалт зэргийг тусгасан байна.

4.5. Зөвлөх инженерийн зэрэг олгох сургалтын хөтөлбөрийн сэдэвт салбарын бодлого, төлөвлөлт, техник, технологийн хөгжлийн чиг хандлага, шинэ технологи, стандарт, техникийн зохицуулалт, үйлдвэрийн ерөнхий төлөвлөлт, техник-эдийн засгийн үндэслэл, инженерийн зураг төсөл боловсруулах ажлыг хийж гүйцэтгэх, төсөл удирдах, хэрэгжүүлэх, төслийн менежмент, эрсдэлийн үнэлгээ хийх чадавхийг бий болгох зэрэг сургалтууд багтсан байна.

4.6. Сургалт явуулах хэлбэр нь танхимын болон танхимын бус сургалт хэлбэртэй байна. Сургалтын үргэлжлэх хугацаа нэг сараас доошгүй байна.

4.6.1. Танхимын бус сургалтаар бүтээлийг үнэлэх, багц цаг тооцох

- 4.6.1.1. Салбарын мэргэжилтний мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалтын багц цагийг танхимын хичээл болон танхимын бус үйл ажиллагааны хэлбэрээр хангаж болно. Мэргэшсэн зэрэгтэй мэргэжилтэн нь танхимын бус хэлбэрээр, зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй мэргэжилтэн нь танхимын сургалтын хэлбэрээр нийт багц цагийн тус тус 30-аас доошгүй хувийг хангасан байна.
- 4.6.1.2. Мэргэшүүлэх сургалтын танхимын хичээлийн 16 цагийг сургалтын 1 багц цаг, чадавхижуулах сургалтын танхимын хичээлийн 32 цагийг сургалтын 1 багц гэж тооцож болох ба сургалтын хөтөлбөрийн агуулгыг Зөвлөл хэлэлцэн тухайн сургалтын багц цагийн хэмжээг батална.
- 4.6.1.3. Мэргэжилтэн нь танхимын хичээлд биечлэн бүрэн оролцсон тохиолдолд тухайн хөтөлбөрт заасан багц цагийг хангасанд тооцно.
- 4.6.1.4. Зэрэг горилогч нь бүтээлийн тайланг Загвар №1-ийн дагуу, зэрэг сунгах болон ахиулах мэргэжилтэн нь зэрэг авснаас хойш хийсэн бүтээлийн тайланг мэргэжил дээшлүүлсэн бодит цагийн хэмжээгээр тооцож Загвар №2-ийн дагуу гаргаж нотлох баримт материалыг хавсаргана.

Загвар №1

..... овогтойбүтээлийн тайлан

№	Бүтээлийн нэр	Гүйцэтгэсэн хугацаа, он, сар	Өөрөө гүйцэтгэсэн, оролцсон, хэрэгжүүлсэн аль нь болох	Шийдвэр гаргасан, баталгаажуулсан байгууллага, албан тушаалтан

Тайланг бичсэн зэрэг горилогч :

/ /

Хянаж баталгаажуулсан:

/ /

Загвар №2

..... овогтой-ний мэргэжил дээшлүүлсэн тайлан

№	Мэргэжил дээшлүүлсэн хэлбэр, агуулга, сэдэв	Хугацаа он, сар, өдөр	Хамтарч оролцсон байдал	Бодит цагийн хэмжээ	Багц цагт шилжүүлсэн

Тайланг бичсэн зэрэг горилогч :

/ /

Хянаж баталгаажуулсан:

/ /

- 4.6.2. Салбарын мэргэжилтний мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалтын багц цагийг танхимын бус дараахь хэлбэрийн үйл ажиллагаагаар хангаж болно. Үүнд:

а. Салбарын чиглэлээр хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандартын төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан ба тухайн баримт бичиг нь батлагдсан бол 4 багц цаг;

б. Салбарын чиглэлийн хууль эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандартад санал өгч тусгуулсан, шүүмж хийсэн бол 1 багц цаг;

в. Мэргэжлийн заавар, зөвлөмж, гарын авлага гаргасан бол 5 багц цаг;

г. Мэргэжлийн ном, нэг сэдэвт бүтээл нийтлүүлсэн бол 10 багц цаг;

д. Мэргэжлийн сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн бол нэг өгүүлэл тухайн сэдвийн чиглэлээр 2 багц цаг;

е. Магистрын зэрэг хамгаалсан бол хамгаалсан сэдвийн чиглэлээр 10 багц цаг;

ё. Докторын зэрэг хамгаалсан бол хамгаалсан сэдвийн чиглэлээр 30 багц цаг;

ж. Салбарын чиглэлээр төсөл, хөтөлбөр боловсруулах, судалгаа хийх ажлын хэсэгт ажиллаж, ажлын тайлан, илтгэлийг нийтлүүлсэн бол тайлан тус бүрээр 4 багц цагийг ажилласан хүний тоогоор хувь тэнцүүлэн;

з. Шинээр бэлтгэсэн илтгэл, хичээлийн лекц /Заасан сэдвийн чиглэлээр хичээлийн 4 цаг тутамд 1 багц цаг/;

и. Их, дээд сургууль төгсөгчийн дипломын ажил удирдсан /1 оюутан-0.5 багц цаг/;

к. Шалгалтын асуулт, тест боловсруулсан /багц бүр нь 20 асуулт бүхий 10 багц тест - 0,5 багц цаг/;

л. Шалгалтын комиссын бүрэлдэхүүнд орж ажилласан /1 удаа-0,5 багц цаг/.

4.6.3. Мэргэжилтэн нь танхимын бус хэлбэрээр багц цаг хангасан тодорхойлолтыг өөрөө гаргаж, зохих нотлох баримтын хамт салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад жил бүр ирүүлж байна. Зөвлөл нь танхимын бус хэлбэрээр багц цаг олгох асуудлыг жил бүр хэлэлцэн шийдвэрлэж хариу мэдэгдэнэ.

4.7. Танхимын сургалтын нийт цаг 150 цагаас багагүй байна.

Тав. Шалгалт

5.1. Зөвлөл нь Мэргэшсэн болон Зөвлөх инженерийн зэрэг олгох шалгалт авах комиссыг /цаашид "Комисс" гэх/ тухай бүрд нь томилж ажиллуулна.

5.2. Комисс нь ашиг сонирхолын зөрчилгүй хөндлөнгийн гишүүдээс бүрдсэн байна.

5.3. Комисс нь сургалтын байгууллагаас ирүүлсэн нэрсийн жагсаалтанд орсон зэрэг горилогчдоос шалгалтыг зөвхөн нэг удаа, тест хэлбэрээр авна.

5.4. Комисс шалгалтанд 90 болон түүнээс дээш оноо авсан зэрэг горилогчдын шалгалтын хуудсыг Зөвлөлд хүргүүлнэ.

5.5. Шалгалтанд тэнцээгүй зэрэг горилогчид нь дараагийн зарлагдах сургалтанд хамрагдан шалгалт өгнө. Энэ тохиолдолд сорилын шалгалтаас чөлөөлөгдөнө.

Зургаа. Мэргэшсэн ба Зөвлөх инженерийн зэрэг олгох

6.1. Сургалтын байгууллага нь шалгалтанд тэнцсэн зэрэг горилогчдын бүртгэл, шалгалтын хуудас, зэрэг олгуулах тухай саналаа Зөвлөлд хүргүүлнэ.

6.2. Салбарын инженерүүдэд Мэргэшсэн болон Зөвлөх инженерийн зэрэг олгох тухай Зөвлөлийн саналыг үндэслэн салбар хариуцсан Засгийн газрын гишүүн тушаал гарган батламжилна.

6.3. Мэргэшсэн болон Зөвлөх инженерийн зэрэг олгох ёслолын ажиллагаа салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дээр явагдана.

6.4. Энэхүү ёслолын ажиллагаан дээр тангараг өргөснөөр Мэргэшсэн болон Зөвлөх инженерийн зэрэг хүчин төгөлдөр болсонд тооцогдоно.

Долоо. Мэргэшсэн ба Зөвлөх инженерийн эрх үүрэг

- 7.1. Мэргэшсэн ба Зөвлөх инженер нь Зөвлөлөөс баталсан загвар бүхий батламж, энгэрийн зүүлт, баталгааны тэмдэгтэй байна.
- 7.2. Батламж дээр тухайн зэрэгтэй инженерийн эрхлэх ажил үйлчилгээний хүрээг тодорхойлсон байна.
- 7.3. Баталгааны тэмдэг дээр эзэмшигчийн нэр, бүртгэлийн дугаар, зэргийн хүчинтэй хугацааг заана.
- 7.4. Мэргэшсэн зэрэгтэй инженер нь зөвхөн өөрөө гүйцэтгэсэн, оролцсон эсвэл удирдсан, хянасан ажлын гүйцэтгэлийн тайлан, дүгнэлт, техникийн акт, баримт бичиг, зураг төсөлд гарын үсэг зурж, баталгааны тэмдгээ дарж баталгаажуулна.
- 7.5. Зөвлөх зэрэгтэй инженер нь зөвхөн өөрөө гүйцэтгэсэн, оролцсон эсвэл удирдсан, хянаж зөвлөсөн үйлдвэрийн ерөнхий төлөвлөлт, стандарт, техникийн зохицуулалт, техник эдийн засгийн үндэслэл, инженерийн зураг төсөл, ажлын гүйцэтгэлийн тайлан, дүгнэлт, техникийн акт, баримт бичигт гарын үсэг зурж, баталгааны тэмдгээ дарж баталгаажуулна.
- 7.6. Мэргэшсэн ба Зөвлөх инженер нь холбогдох хууль тогтоомжид заасан нэмэгдэл, цалин хөлсийг авах эрхтэй.
- 7.7. Мэргэшсэн инженерийн зэрэг 3 жил, Зөвлөх инженерийн зэрэг 5 жилийн хугацаанд хүчинтэй.
- 7.8. Мэргэшсэн ба Зөвлөх инженер нь зэрэг сунгуулах тохиолдолд сургалтанд хамрагдаж багц цагийг хангаж, шалгалт өгөх үүрэгтэй.

Найм. Мэргэшсэн болон Зөвлөх инженерийн зэргийг цуцлах

- 8.1. Зэрэг сунгах сургалтанд хамрагдаагүй Мэргэшсэн болон Зөвлөх инженерийн зэргийг Зөвлөлийн саналыг үндэслэн салбар хариуцсан Засгийн газрын гишүүн цуцална.
- 8.2. Мэргэжлийн ёс зүйн алдаа гаргасан, гүйцэтгэсэн, удирдан хийлгэсэн, хянаж баталгаажуулсан ажлын чанар нь шаардлага хангаагүй нь хөндлөнгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд Зөвлөлийн саналыг үндэслэн салбар хариуцсан Засгийн газрын гишүүний тушаалаар тухайн инженерийн зэргийг цуцална.
- 8.3. Зөвлөл нь зэргээ цуцлуулсан инженерээс олгосон батламж, энгэрийн зүүлт, баталгааны тэмдгийг хураан авна.
- 8.4. Мэргэжлийн ёс зүйн алдаа гаргаж, зэргээ цуцлуулсан инженер нь батламж, энгэрийн зүүлт, баталгааны тэмдгээ Зөвлөлд хураалгаагүй тохиолдолд тухайн инженерийн зэрэг хүчингүй болсон талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлаж мэдэгдэнэ.

о О о

“Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн “Үндэсний ажил, мэргэжил, албан тушаалын жагсаалт, ангилал, тодорхойлолт батлах тухай” 16 дугаар тушаалын 1,2 дугаар хавсралт”.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2017 оны 0/р сарын 03 ний өдрийн
А/0/ тушаалын хоёрдугаар хавсралт

**1. Металлурги, машин үйлдвэрлэл, метал боловсруулалтын салбарын
мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох зөвлөлийн бүрэлдэхүүн**

Зөвлөлийн дарга:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Орлогч дарга:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын
мэргэжилтэн

Гишүүд:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын
дарга

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах
газрын дарга

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын дарга

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын
мэргэжилтэн

Үндэсний аж үйлдвэрийн зөвлөлийн гүйцэтгэх захирал

Үндэсний аж үйлдвэрийн зөвлөлийн сургалт хариуцсан ажилтан

Үндэсний аж үйлдвэрийн зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн

ШУТИС-ийн Механик тээврийн сургуулийн захирал

ШУТИС-ийн Механик тээврийн сургуулийн Машин үйлдвэрлэлийн салбарын
профессор

ШУТИС-ийн Механик тээврийн сургуулийн Мэргэжил дээшлүүлэх сургалт
хариуцсан мэргэжилтэн

**2. Нефть химийн салбарын мэргэжилтэнд мэргэшлийн
зэрэг олгох зөвлөлийн бүрэлдэхүүн**

Зөвлөлийн дарга:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Орлогч дарга:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын
мэргэжилтэн

Гишүүд:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын
дарга

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын мэргэжилтэн

Үндэсний аж үйлдвэрийн зөвлөлийн гүйцэтгэх захирал

Үндэсний аж үйлдвэрийн зөвлөлийн сургалт хариуцсан ажилтан

ШУТИС-ийн Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн захирал

ШУТИС-ийн Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн Химийн инженерчлэлийн салбарын эрхлэгч

ШУТИС-ийн Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн Химийн инженерчлэлийн салбарын профессор

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2017 оны 2/р сарын 03 ний өдрийн
А/0/ тушаалын гуравдугаар хавсралт

**САЛБАРЫН МЭРГЭЖИЛТЭНД МЭРГЭШЛИЙН
ЗЭРЭГ ОЛГОХ ХҮРЭЭ**

1. Аж үйлдвэрийн инженер техникийн ажилтаны мэргэших хүрээнд:

- 2141-11 Инженер, аж үйлдвэрийн
- 2141-12 Инженер, байгууламжийн
- 2141-13 Инженер, машин тоног төхөөрөмжийн
- 2141-17 Инженер, техник засварын
- 2141-18 Инженер, төлөвлөлтийн
- 2141-19 Инженер, төсвийн
- 2141-25 Инженер, хөдөлмөрийн аюулгүй байдлын
- 2141-28 Инженер, чанарын
- 2141-35 Инженер, хэмжил зүй, эталоны, шалгалт, тохируулгын

2. Механик инженер техникийн ажилтаны мэргэших хүрээнд:

- 2144-14 Загвар зохион бүтээгч, машины
- 2144-35 Механикч инженер, машин механизмын
- 2144-38 Механикч инженер, үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмжийн
- 2144-43 Механикч инженер, хөдөө аж ахуйн
- 2144-45 Технологич, гагнуурын
- 2144-46 Технологич инженер, механикийн

3. Металлургич инженер техникийн ажилтаны мэргэших хүрээнд

- 2146-11 Инженер, баяжуулалтын
- 2146-16 Инженер, төмөрлөгийн хүдрийн
- 2146-24 Технологич, хайлахын
- 2146-25 Технологич, цутгахын
- 2146-26 Технологич, цувихын
- 2146-27 Металлургич, олборлолтын
- 2146-28 Металлургич, радио идэвхт эрдэс бодисын
- 2146-29 Металлургич, физикийн
- 2146-30 Шинжээч төмөрлөгийн хүдрийн

2146-31 Инженер, төмөрлөгийн, хяналт туршилтын

2146-32 Инженер, спекторийн

2146-35 Инженер, төмөр бэлтгэх талбайн

2146-36 Төмөрлөгийн инженер, цутгахын

4. Химийн инженер техникийн ажилтаны мэргэших хүрээнд:

2113-21 Металлын зэврэлт судлагч химич

2113-22 Нефтийн химич

2113-40 Төмөрлөгийн химич

2113-46 Уусган баяжуулалтын хими-технологич

2113-47 Ховор элементийн хими-технологич

2113-50 Газрын тосны хими-технологич

2145 Химийн инженер /2145-11- ээс 2145-27 хүртэл/

5. Боловсруулах үйлдвэрлэлийн менежер /1321-12/

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2017 оны 01 сарын 03 ний өдрийн
А/0/ тушаалын дөрөвдүгээр хавсралт

Салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгоход тавих шаардлага

1116127151
УХА0580 9129294

Мэргэжил	Горилж буй мэргэшлийн зэрэг	Мэргэшлийн зэрэг горилох мэргэжилтэнд тавигдах шаардлага	Мэргэшлийн зэрэг олгох шалгаруулалтын үйл ажиллагааны үе шат	Мэргэжилтний мэргэшлийн зэргийг сунгах, ахиулах, цуцлах үе шат			
Мэргэжилтэн гэдэгт төмөрлөг, машин үйлдвэрлэл, нефть химийн чиглэлээр ажил үйлчилгээ эрхэлж буй инженер, технологич, эдийн засагч хамаарна.							
Инженер, технологич, эдийн засагч	Мэргэшсэн	Боловсрол	Төрөөс баримтлах боловсролын стандартыг хангасан их, дээд сургууль төгсөж дээд /дипломын, бакалаврын, магистрын, доктор/ боловсрол эзэмшсэн байна.	1. Мэргэжилтний бүтээл туршлагыг магадлан үнэлэх /Загварын дагуу гаргасан бүтээлийн тайланг хянан магадлана/ 2. Мэргэжлийн болон ур чадварын шалгалт /салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, норм норматив, стандарт, дүрэм, журам, зааврын мэдлэгийг шалгах бичгээр хариулах асуулт болон тест байх ба авбал зохих нийт онооны 90 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно/ 3. Мэргэшлийн зэрэг горилогч нь шалгалтанд тэнцээгүй бол дахин шалгалт өгөх хүсэлтээ бичгээр гаргасны үндсэн дээр дахин	Мэргэшсэн зэрэгтэй мэргэжилтэн нь 5 жил тутамд нийтдээ 2 удаа зэргээ сунгаж баталгаажуулах ба хоёр дахь сунгалтаас гэрчилгээнд хугацаа	Зэрэг сунгах үйл явц	Зэргээ сунгуулах хүсэлтийг зэрэг авснаас хойшхи хугацаанд хийсэн ажил болон мэргэжил дээшлүүлсэн талаархи тайлан, тодорхойлолтын хамт зэргийн хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө зөвлөлд ирүүлнэ.
		Ажилласан жил	Дипломын дээд боловсрол эзэмшсэнээс хойш мэргэжлээрээ 6-аас дээш жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх				Мэргэшсэн зэргийн хугацаагаа сунгуулахдаа 30 кредит кр цаг хангасан тохиолдолд Зөвлөлд хүсэлт гаргана:
			Бакалаврын зэрэгтэй бол 5-аас дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх				<ul style="list-style-type: none"> Өөрийн биеэр ирж ажлаа шалгалтын комиссоод тайлагнана. Мэргэжлийн чиглэлээр 1-ээс доошгүй хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт боловсруулахад

			<p>Магистрын зэрэгтэй сэл 4-өөс дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх</p> <p>Шинээр зэрэг горилогчид нь мэргэжлийн ерөнхий мэдлэгийн шалгалт өгсөн байх</p>	<p>шалгалт өгч болох ба харин дахин шалгалтыг эхний удаа шалгалт өгсөн жилээс хойш дараагийн 2 жилийн дотор багтааж өгөх, хэрэв энэ 2 жилийн хугацаанд өгсөн дахин шалгалтанд тэнцээгүй тохиолдолд сургалтад дахин хамрагдана.</p>		<p>заавал оролцсон, хянан тохиолдуулсан, санал өгч тусгуулсан, заавар, зөвлөмж, гарын авлага гаргасан байх</p> <ul style="list-style-type: none"> 80 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд сунгана
Инженер, технологич, эдийн засагч	Зөвлөх:	Боловсрол	<p>Төрөөс баримтлах боловсролын стандартыг хангасан их, дээд сургууль төгсөж дээд /бакалавр, магистр болон доктор/ боловсрол эзэмшсэн байх</p>	<p>1. Мэргэжилтний бүтээл туршлагыг магадлан үнэлэх /Загварын дагуу гаргасан бүтээлийн тайланг хянан магадлана./</p> <p>2. Мэргэжлийн болон ур чадварын шалгалт /салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, норм дүрэм, стандарт, журам, заавар, зөвлөмжийн талаарх мэдлэгийг шалгах бичгээр хариулах асуулт болон тест байх ба авбал зохих нийт онооны 90 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно/</p>	Зөвлөх зэрэгтэй мэргэжилтэн нь 5 жил тутамд нийтдээ 2 удаа зэргээ сунгаж баталгаажуулах ба хоёр дахь сунгалтаас дараагийн сунгалтаас зэргээ	<p>Мэргэшлийн зэргийн хүчинтэй байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө материалаа зөвлөлд ирүүлнэ. Зөвлөх зэргийн хугацаагаа сунгуулахдаа 30 кредит цаг хангасан тохиолдолд Зөвлөлд хүсэлт гаргана.:</p> <ul style="list-style-type: none"> Өөрийн биеэр ирж хийсэн ажлаа шалгалтын комиссоод тайлагнана. Мэргэжлийн чиглэлээр 1-ээс доошгүй хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт, заавал бие даан боловсруулсан, хянан тохиолдуулсан, 2-оос доошгүй санал өгч тусгуулсан, заавар, зөвлөмж, гарын авлага гаргасан байна.

		Ажилласан жил	<p>Мэргэшсэн зэрэг авснаас хойш мэргэжлээрээ 6 ба түүнээс дээш жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байна.</p>	<p>3. Тайлан, сэдвийн хамгаалалт /илтгэлийн хураангуй (реферат) бичих, техник технологийн шийдэл, зураг төсөл, төсөвт экспертиз хийж хамгаалан 90 буюу түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно/</p> <p>4. Мэргэшлийн зэрэг горилох болон зэрэг сунгах шалгалтанд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас орж чадаагүй бол уг шалтгааныг нотолсон баримт бичгийг бүрдүүлж, дараагийн ээлжит шалгалтад оролцох хүсэлтээ Зөвлөлд бичгээр илэрхийлнэ.</p>		Зэрэг ахиулах үйл явц	<p>Мэргэшсэн зэргийг зөвлөх зэрэгт ахиулахдаа:</p> <ul style="list-style-type: none"> • 30 кредит цагийн танхимын болон танхимын бус сургалтанд хамрагдсан байх • Мэргэшсэн зэргээ зөвлөх зэрэгт ахиулах хүсэлт гаргасан бол зэрэг сунгах бүтээлийн тайлан, хамгаалалтанд орж тэнцсэн байна. • Мэргэжлийн болон ур чадварын мэдлэгийг шалгах тестийн шалгалтанд авбал зохих нийт онооны 80 буюу түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн байна. • Тайлан, сэдвийн хамгаалалтад 80 буюу түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн байна. • Мэргэжлийн чиглэлээр 1-ээс доошгүй хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт заавал бие даан боловсруулсан, хянан тохиолдуулсан, 2-оос доошгүй санал өгч тусгуулсан, заавар, зөвлөмж, гарын авлага гаргасан байна.
--	--	---------------	---	--	--	-----------------------	--

Бусад шаардлага

Мэргэжлийн хүрээний
чиглэлээр докторын
зэрэг хамгаалсан
тохиолдолд Зөвлөх
зэрэг горилогчийн
бичгээр уламжилсан
хүсэлтийг үндэслэн
мэргэжлийн болон
сэдвийн хамгаалалтын
шалгалтаас чөлөөлж
болно.

Дараах тохиолдолд мэргэшлийн болон зөвлөх зэргийг цуцлах болно. Үүнд:

- Мэргэшлийн болон зөвлөх зэргээ бууруулах, эсвэл цуцлуулах хүсэлтийг мэргэжилтэн өөрөө гаргасан,
- Ажиллах хугацаандаа тодорхой кредит цаг хангаагүй
- Мэргэшлийн болон зөвлөх зэргийн хүчинтэй хугацаа хэтэрсэн болон зэрэг авсан хугацаанд мэргэжлээрээ ажиллаагүй
- Шалгаруулалтад хугацаандаа ороогүй,
- Шалгаруулалтад тэнцээгүй
- Мэргэжлийн алдаа дутагдал гаргасан /мэргэжлийн хяналтын газар болон холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлт эсхүл шүүхийн шийдвэрээр нотлогдсон/.
- Ёс зүйн доголдол гаргасан.

Мэргэшлийн зэргээ бууруулсан, цуцлуулсан мэргэжилтэн алдаа дутагдалаа зассанаа тодорхой баримтаар, ажил үйлчилгээгээг нотолсон тохиолдолд Зөвлөлд хүсэлт гаргаж, дахин шалгалтад орох эрхтэй.

Зэрэг цуцлах үйл явц